



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ-2023 СУУРЬ БОЛОВСРОЛ



НИЙГЭМ СУДЛАЛ

ХУВИЛБАР А

Аймаг / дүүрэг:

Сум / сургууль:

Анги / бүлэг:

Сурагчийн овог:

Сурагчийн нэр:

Сурагчийн код:

18. Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хэдэн онд баталсан бэ?

- A. 1945 он B. 1946 он C. 1948 он D. 1949 он

19. Хүснэгтийн хоосон зайд тохирох ойлголтыг өгөгдлүүдээс олно уу.

Өгөгдөл: /1-Цагдаагийн байгууллага, 2-Иргэний шүүх, 3-Захиргааны шүүх, 4-Хүний эрхийн үндэсний комисс/

a.....	Иргэд хоорондын гэрээний дагуу эд зүйл, өмч хөрөнгийг өмчлөхтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх
b.....	Захиргааны албан тушаалтан иргэдийн эрхийг зөрчсөн шийдвэр гаргасныг цуцлах

- A. a1b2 B. a2b3 C. a1b4 D. a1b3

20. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг дурдахдаа илүүц зүйл дурдсаныг олно уу.

- A. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь олон улсын гэрээгээр баталгаажсан байдаг
B. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь олон улсын конвенцоор баталгаажсан байдаг
C. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь тухайн улсын хуулиар баталгаажсан байдаг
D. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хуулиар баталгаажуулах шаардлагагүй чөлөөтэй илэрхийлэх ёстой

21. Хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллага аль вэ?

- A. Засгийн газар B. Улсын Их Хурал C. Шүүх D. Үндсэн хуулийн цэц

22. Шүүх хуралдаанд оролцох дүрүүдээс аль нь илүүц вэ?

- A. хоёрдогч этгээд B. нэхэмжлэгч C. хариуцагч D. иргэдийн төлөөлөгч

23. Монгол улсын “Хүүхэд хамгааллын тухай хууль” хэдэн онд батлагдсан бэ?

- A. 2016 он B. 1990 он C. 1989 он D. 1948 он

24. Улсын Их Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр аль нь вэ?

- A. Засгийн газар B. Чуулган C. Байнгын хороо D. Нэгдсэн чуулга

25. Шүүхийн үндсэн чиг үүрэг аль вэ?

- A. Хуулийг хэрэгжүүлэх, биелүүлэх
B. Хууль батлах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах
C. Үндсэн хууль зөрчсөн эсэх талаарх маргааныг шийдэх
D. Хэрэг маргааныг хууль ёсонд нийцүүлэн шийдвэрлэх

26. Ардчилсан бус дэглэмийн шинжид аль нь хамаарахгүй вэ?

- A. Эрх мэдэл нэг хүний гарт төвлөрдөг
B. Цөөнхийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьдаг
C. Ард иргэдийн хүсэл зоригийг үл харгалзан, үйл ажиллагаа явуулдаг
D. Төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх байгууллагад хуваарилдаг.

САНАМЖ

- Хоёрдугаар хэсгийн даалгаврыг (2.1) гүйцэтгэхдээ хариултын хуудас дахь САНАМЖ хэсэгт байгаа зааврын дагуу зөв хариултыг будаарай.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

2.1 МУ-ын шүүх үйл ажиллагааны зарчмуудыг зөв холбоно уу.

a	Хууль дээдлэх, хуульд захирагдах	1	Шүүх хуралдаанд талууд тэдгээрийн өмгөөлөгч хууль ёсны төлөөлөгч болон улсын яллагагчид асуулт асуух, хариулах, нотлох баримт танилцуулах гэх мэт боломжийг тэгш олгох
b	Нэгдмэл байх	2	Хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн нөлөөнөөс ангид байх
c	Шүүх нээлттэй ил тод байх	3	Албан ёсны хүчин төгөлдөр хуулиа мэдэх, хэрэглэх, дээдлэн сахиж гуйвуулахгүй байх
d	Мэтгэлцэх	4	Шүүх шийдвэр үйл ажиллагааг нийтэд тогтмол мэдээлж байх
e	Шүүх бие даасан байх	5	Аливаа шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж болохгүй